

**“ИРГЭДИЙН ИНДЭР-3 НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”-Т ИРГЭД, ОЛОН НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ ХҮСЭЛТИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ТУСГАЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

Дархан-Уул аймаг

д/д	Чиглэл	Санал хүсэлтийн товч утга	Хариуцах албан тушаалтан, байгууллага	Хэрэгжилт
1	Нийгмийн харилцаа	Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн огцом өсөлт дээр ажлын хэсэг байгуулж, үр дүнтэй ажил хийх	С.Энхболд Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын дарга	<ol style="list-style-type: none"> <li>Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нөөцийн болон үнийн өсөлтийн судалгааг өмнөх оны мөн үе, 2022 оны 1 дүгээр улиралтай харьцуулсан байдлаар гаргасан.</li> <li>Сүрээгийн эмчилгээ хийлгэж буй 50 иргэнд хүнсний тусламжийг үзүүлсэн. 5, 6 дугаар саруудад 100 иргэнд тусламж үзүүлнэ. /УЗХороо/</li> <li>Катар Улсын УЗНийгэмлэгийн тусламжаар 100 өрхөд хүнс, ариутгалын багцын тусламжийг үзүүлж байна.</li> <li>Төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр зорилтот бүлгийн 200 өрхөд хүнсний тусламжийг үзүүлж байна.</li> </ol>
2		Дархан-Уул аймагт электрон тамхийг хэрэглэх, худалдан борлуулахыг хориглох	Д.Бат-Эрдэнэ Мэргэжлийн хяналтын газрын дарга	2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Мэргэжлийн хяналтын газраас холбогдох асуудлаар 10 хуудас тайланг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.
3		Дархан захын үүднээс орон нутагруу хүн тээвэрлэдэг тендерийн автомашинуудыг Буян захын хашаан дотор шилжүүлэх	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Дархан захын үүднээс Сэлэнгэ аймгийн сумдад хүн тээвэрлэдэг авто машинуудыг захын хашаан дотор оруулах зогсоолын зохион байгуулалтын талаар Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ, “Дархан тээвэр” ХХК саналаа боловсруулан ирүүлж, хамтран ажиллаж байна.
4	Эрүүл мэнд	Эрүүл мэндийн чиглэлээр сар бүр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах	Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Батцэнгэл Эрүүл мэндийн газрын дарга	Нэгдсэн эмнэлэг, Өрх, Сумын эрүүл мэндийн төвүүдтэй хамтран сар бүр Эрүүл мэндийн чиглэлээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж байна.
5	Боловсрол	Хүүхдийг хүчирхийллээс сэргийлэх ажлын хэсэг байгуулж ЕБ-ын 12 дугаар дунд сургууль дээр ажиллах, дүгнэлт гаргах	Н.Цасчихэр Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ Мэргэжлийн хяналтын газрын дарга С.Галбадрах БШУГ-ын дарга	Нийгмийн бодлогын хэлтэсийн дарга (Н.Цасчихэр) ахалсан ажлын хэсэг дүгнэлтээ гаргаж олон нийтэд цахимаар танилцуулсан.

			Д.Ганзориг Цагдаагийн газрын дарга	
6		ОИ цогцолбор сургуулийн өргөтгөлийн ажлыг бүх талаар судлан төсөвт суулгахад бэлэн болгох	П.Батсүх Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлсийн дарга Д.Батчулуун Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	960 хүүхдийн эко сургууль барихаар 2023 оны улсын төсөвт тусгах санал зураг, төсвийг програмд оруулсан.
7	Дэд бүтэц	25 дугаар хороололд шинээр тавигдсан гэрлүүдийг асаах	Б.Батболд Хотын захирагчийн орлогч Ч.Батжаргал Захирагчийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	2022 оны 5 дугаар сард багтаан дутуу байгаа 60 гэрэл болон ажиллаж байгаад шатсан 14 гэрлийг бүрэн тавьж дуусгана. Одоо 82 гэрэл орой 19:30 цагаас 06:00 цаг хүртэл асч байна.
8		ЕБ-ын Од цогцолбор сургуулийн авто замыг нэг урсгалтай болгох боломжийг судалж танилцуулах	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга Д.Ганзориг Цагдаагийн газрын дарга	Замын цагдаагийн газраас нөхцөл байдалтай танилцлаа. 20м орчим газар үүссэн шороог тэгшилж засах шаардлагатай гэж дүгнэсэн.
9		Хийн хоолойн асуудлаар ажлын хэсэг байгуулах (Засаг даргын захирамжаар)	Д.Батчулуун Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	Аймгийн Засаг даргын 2022.04.14-ны өдрийн 01-А/110 тоот захирамжаар судалгааны ажилд шаардлагатай холбогдох мэдээллээр хангах ажлын хэсгийг байгуулсан.
10	Газрын харилцаа	Дархан сумын 9 дүгээр баг 4-ийн 3 дугаар байрны хажууд олгогдсон хууль бус газрыг цуцлах	Д.Батчулуун Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	Газар эзэмших эрхийг цуцлах тухай аймгийн Засаг даргын захирамжийн төсөл хянагдаж байна.
11		(Хүслийн хотхон)14 дүгээр хорооллын газар олголтын асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга Д.Батчулуун Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	Тус хороололд: аймгийн Засаг Даргын 2018.06.04-ны өдрийн 01-А/211 дүгээр захирамжаар 57 иргэнд, 2018.12.27-ны өдрийн 01-А/470 дугаар захирамжаар 35 иргэнд, 2020.07.08-ны өдрийн 01-А/252 дугаар захирамжаар 14 иргэнд, нийт 115 иргэнд газар олгосон . 2022 оны 5 дугаар сарын эхний долоо хоногт хэлэлцүүлэг зохион байгуулна.
12	Хот тохижилт	Дархан сумын орон сууцны байруудын 1 дүгээр давхарт байрладаг зочид буудлуудын үйл ажиллагааг өөр чиглэлээр явуулдаг болгох	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга	Дархан сумын хэмжээнд орон сууцны 1 дүгээр давхарт үйл ажиллагаа явуулдаг 4 дэн буудлууд нь стандартын шаардлага хангаагүй тул тохирлын гэрчилгээ олгогдоогүй.
13		18 дугаар дэлгүүрийн замын эсрэг талын буудал	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга	ТҮЦ-үүдийг нүүлгэн шилжүүлж, хог хаягдлыг татан зайлуулсан. Камержуулах төсөв суугдсан байна.

		дээрх эзэн нь олдохгүй байгаа ТҮЦ-ийг нүүлгэн шилжүүлж, камержуулах		
14		Дархан захын замын эсрэг талын Хаан банкны урд автомашины зогсоолд өргөтгөл хийх асуудлыг судалж танилцуулах	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга Д.Батчулуун Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	Нүхэн гарц байрладаг тул авто машины зогсоол нэмж төлөвлөх боломжгүй.
15		Дархан суманд зүлэгжүүлэлтийн ажлыг эхлэх, Хонгор сумаас хар шороо татаж буулгах	З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	Хонгор сумаас нэг машин хар шороо татаж буулгасан. Газар хөлдүү байгаа учир дараагийн хар шороо хүлээгдэж байна. Зүлэгжүүлэлтийн ажлыг хуучин Дархан гандангийн зам дагуу эхлүүлсэн.
16		Сарын аяны хүрээнд Дархан суманд 2 багийг сонгон авч жишиг хороолол болгох	Т.Тулгаа Дархан сумын Засаг дарга	Хугацаа болоогүй.
17		“Дархан 50” цогцолборын нийтийн 00-ыг ажиллуулах	З.Эрдэнэбат Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын дарга	“Дархан 50” цогцолборын нийтийн 00 гэсээгүй тул түр хүлээгдэж байна. 4 дүгээр сарын 27-нд ажиллаж эхэлнэ.

### ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС